

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТАЛААР

ЗГ-ын 2015 оны 7 сарын 7-ны 291-р тогтоолоор “Замын-Үүд” чөлөөт бүсийн 1 га газрын суурь үнэлгээг тогтоосон.

Чөлөөт бүсийн нэр	1 га газрын суурь үнэлгээ /төгрөг/ /газар ашиглалтын зориулалтаар	
	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	Хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл
Замын-Үүд	150,000,000.0	120,000,000.0

Чөлөөт бүсийн тухай хуулийн дагуу чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглахад **газрын нэг удаагийн төлбөр** төлнө.

БХБ Сайдын 2015 оны 234 дүгээр /Газар эзэмших ашиглах дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал/ тогтоолд **үйлдвэрийн чиглэлээр 0.08 үйлчилгээний чиглэлээр 0.1** гэсэн /засварлах итгэлцүүрээр/ тооцож газрын нэг удаагийн төлбөрийг тогтооно.

Жишээ. “Замын-Үүд” чөлөөт бүсэд үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшүүлэх 1000 м^2 газрын эзэмших эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлье.

$12,000.0 \text{ төг/м}^2 \times 0,08 \times 1000 \text{ м}^2 = 960,000.0 \text{ төгрөг}$ болж байна.

ЗГ-ын 2015 оны 7 сарын 7-ны 291-р тогтоолоор “Замын-Үүд” Чөлөөт бүсийн 1 га газрын жилийн төлбөрийн хязгаарыг суурь үнэлгээний 1,0 хувь байхаар тогтоосон байдаг.

1га газрын жилийн төлбөр:

- Худалдаа бүх төрлийн үйлчилгээ: **1,500.000₮**
- Хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл: **960.000₮**

Хөнгөлөлт

Чөлөөт бүсийн хуулийн дагуу:

- Худалдаа
- Аялал жуулчлал
- Зочид буудлын чиглэлээр **эхний 5 жилд 100 хувь, дараагийн 3 жилд 50 хувь,**

Дэд бүтэц болон үйлдвэрлэлийн чиглэлээр **эхний 10 жилд 100 хувиар** тус тус газрын жилийн төлбөрөөс чөлөөлнө.